“Анагаах ухааны цог төгөлдөр дөрвөн үндэс”-ийн “Онолын үндэс”-ийн өвчний ангиллыг тайлбар бүтээлүүдтэй харьцуулан шинжсэн нь

Д.Бямбадолгор[1], Ц.Мөнхтуяа[2], С.Сээсрэгдорж[3]

[1,3]АШУҮИС. МАУОУС
[2]Wellness Med
Цахим шуудан: byambaadorio@gmail.com, Утас: 88125776

Түлхүүр үг:

Уламжлалт
Сурвалж
Өвчин
Ангилал
Тоо

Товч утга:

Үндэслэл: Уламжлалт өвчний ангиллыг дэлгэрүүлэн судлах нь уламжлалт өвчний оношийн мөн чанарыг тогтоож орчин үеийн анагаах ухааны оноштой дүйцүүлэх ач холбогдолтой хэмээн үзэж зарим сурвалж, тайлбаруудын хүрээнд харьцуулан судаллаа. **Үр дүн:** “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалжийн **“**Номлолын үндэс”-ийн өвчний ангилалд 1. Шүтээний ангиллыг гол болгосон хийгээд эрэгтэй, эмэгтэйн өвчний ангиллыг “Алтан хадмал” тайлбарт нэмэлт хийж бичжээ. “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалжийн “Номлолын үндэс”-т өвчнийг гэм, эрхэм, орон, язгуурыг баримтлан ангилаад шүтээний ангиллыг эрхэм болгож хорлогдохуун 25-тай холбон дан, хавсарсан, хурсан олон хувилбараар хэмжээлэшгүй олон гэж тодорхойлохдоо хий, шар, бадган гурван гэмийн хүрээнд хязгаарлаж авч үзээд мөн чанарыг баримтлан ерөнхийд нь халуун, хүйтэн 2-т хурааж авч үздэг уламжлал дамжиж ирсэн байна. Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал нь хий, шар, бадган гурван гэмийн 1. Дангаар 2. Хавсарч 3. Хурж арвидах, барагдах нийт 101 хувилбарыг эх үндэс болгож цаашид “Алтан хадмал” тайлбарт “Шүтээн”-ий ангилал дахь “Эрхэм”-ийн ангиллыг хорлогдохуун 25-тай холбон тэдгээрийн тус бүрийн дангаар арвидах, барагдах, хямралдах болон хавсарч машид, дээдэд арвидаж, барагдахын үржвэрүүдээр дэлгэрүүлэн нийтдээ 682.870.50 өвчинд ангилсан болох нь тогтоогдож байна. **Дүгнэлт:** 1. “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” сурвалжид өвчнийг хэмжээлэшгүй ангилсан хэдий ч хий, шар бадган гурван гэмийн хүрээнд хязгаарлан ерөнхийд нь халуун, хүйтэн 2-т ангилсан байна. 2. Өвчний ангиллыг 3 гэмийн дан, хавсарч, хурсаны арвидаж барагдах 101 хувилбар нь цаашид машид дэлгэрэн ангилагдаж байна. 3. Уламжлалт анагаах ухаанд өвчнийг гэм, эрхэм, орон, язгуурыг баримтлан ангилж байгаагаас шүтээний ангиллын эрхэмийн ангиллыг гол болгож гурван гэмийн хүрээнд тэдгээрийн арвидаж, барагдах, хямаралдахыг дан, хавсарсан, хурсантай ялгавартайгаар, хорлогдохуун 25-тай холбон үржиж дэлгэрүүлэн машид тодорхой тооцож гаргажээ.

Үндэслэл: Хүн төрөлхтөн үүссэн цагаасаа өвчин эмгэгийг эрт танин мэдэх зорилгоор тэдгээрийг тодорхой шалгуураар ангила., бүлэглэх оролдлого хийж байсан нь хөгжлийн явцад өвчний ангиллыг бий болгох үндэс суурь нь болсон.[8] Өвчнийг шинжлэхдээ юун түрүүнд өвчний зүйлийн ангиллын дагуу ямар өвчин байгааг шинжилж тогтоох нь маш чухал бөгөөд үүгээр өвчний гол хүчийг танин барина.[7] Уламжлалт өвчний ангиллыг дэлгэрүүлэн судлах нь өвчний оношийн мөн чанарыг тогтоож орчин үеийн анагаах ухааны оноштой дүйцүүлэн шалтгаан, нөхцөл, орших орон, үе, шат хүндрэлтэй нь уялдуулан эмнэлзүйн дэлгэрэнгүй онош тавих нь өвчлөлийн тархалтын тоо баримт, тайлан мэдээ гаргах, уламжлалт өвчний оношийн мэдээллийн сан бүрдүүлэх, судалгаа хийх, эрүүл мэндийн даатгалаас санхүүжилт авах зэрэгт ашиглах ач холбогдолтой байгаа юм.

Зорилго: Уламжлалт сурвалж зарим тайлбаруудын өвчний ангиллыг харьцуулан тогтоох.

Зорилт:

1. Уламжлалт анагаах ухааны өвчний ангиллыг “Онолын үндэс”-т хэрхэн авч үзсэнийг тодруулах
2. Уламжлалт өвчний ангиллын тоог тогтоох
3. Тайлбаруудын өвчний ангиллын онцлогийг тодруулах

Арга зүй, арга аргачлал:

Үндсэн эх хэрэглэгдэхүүн: Их Ютог Ёндонгомбын “Рашааны шимт найман гишүүнт нууц увдисын үндэс” Бээжин 2013 он. Төвөд хэлээр “Номлолын үндэс”-ийн “Өвчний ангилал”-ын 12-р бүлэг

Харьцуулсан эх хэрэглэгдэхүүн:

1. Дэсрид Санжаажамц Хөх Биндэръяа. Төвөд хэлээр “Номлолын үндэс”-ийн 12-р бүлэг
2. Дармаманрамба Лувсанчойдаг. Алтан хадмал 35-р боть. Бээжин 2002 он, Төвөд хэлээр “Номлолын үндэс”-ийн 12-р бүлэг
3. Торүцэнамжизам “Анагаах язгуур дөрвөн үндсийн дэлгэрэнгүй тайлбар арш гэгээний эш” Төвөд хэлээр.” Номлол үндэс”-ийн 12-р бүлэг
4. Ламын гэгээн Лувсанданзанжанцаны Төвөд хэлээр 1680 оны орчим бичигдсэн “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол оршвой” судар.

Дээрх сурвалж, тайлбаруудыг Төвөд эхээс Монгол хэлэнд орчуулан хөрвүүлэх, тайлбарлах, нэгтгэн дүгнэх, харьцуулан судлахдаа Герменевтик арга[10], Зохиогчийн зүгээс илэрхийлсэн үзэл баримтлалыг Бичвэр судлалын (textual analysis)өргөн хүрээний олон аргачлалуудыг өөртөө багтаадаг (Kathleen Carley, 1993: 77) аргаар харьцуулан судалллаа.[9, 10]

Үр дүн: “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” -ийн “Номлолын үндэс”-ийн өвчний ангиллыг 1. Шалтгаан, 2. Шүтээн, 3. Зүйлийн үүднээс ангилан дэлгэрүүлэн номлосон байна. Гэхдээ Анагаах Ухааны Дөрвөн Үндэс-т өвчнийг хэмжээлэшгүй олон ангилсан ч хий, шар, бадган гурван гэмийн хүрээнд ангилаж бүх өвчинг халуун, хүйтэн хоёрт хураажээ. [1,3]

Хөх Биндэръяа тайлбарын “Шүтээний ангилал”-д эрэгтэйн өвчин 17 зүйлээрээ бүгд адил, харин “Алтан хадмал” тайлбарт арвидах, барагдах орны 12-р бүлэгт эрэгтэйн өвчний ангилалд ивэрхийн ерөнхий 6 өвчин дээр им унжих буюу ивэрхий өвчнийг багтаан 18 болгож ангилжээ.[3] Мөн эмэгтэйн 32 өвчний ангиллыг “Алтан хадмал” тайлбарт 1. Нярайлж ядах, 2. Толгой сүүл буруудах, 3. Рома судалд хүрсэн, 4. Саванд унасан цус салаагүй хэмээн 4-н ангилал нэмж 36 болгожээ.[3]

Хүснэгт 1.“Алтан хадмал” Эрхэмийн ангилалын хий, шар, бадганы дангаар, хавсарч, хурж арвидаж, барагдах ангилал

Шүтээний таван хий, шар, бадганы арвидаж, барагдахын хувилбар	Арвидах	Машид арвидах	Дээдэд арвидах	Барагдах	Машид барагдах	Дээдэд барагдах	Нийт тоо
Амь баригч хий дангаар арвидаж, барагдах	1	1	1	1	1	1	6
Амь баригч хий дангаар шартай хавсарч арвидаж,барагдах	5	5	5	5	5	5	30
Амь баригч хий дангаар бадгантай хавсарч арвидаж, барагдах	5	5	5	5	5	5	30
Амь баригч хийн судал өөр хоорондоо хавсарч арвидаж, барагдах	4	4	4	4	4	4	24
Амь баригч хий 5 шартай хавсарч арвидаж, барагдах	20	20	20	20	20	20	120
Амь баригч хий 5 бадгантай хавсарч арвидаж, барагдах	20	20	20	20	20	20	120
Амь баригч хий дангаар хурж арвидаж, барагдах	6	6	6	6	6	6	36
Амь баригч хий 5 шартай хурж арвидаж, барагдах	10	10	10	10	10	10	60
Амь баригч хий 5 бадгантай хурж арвидаж, барагдах	10	10	10	10	10	10	60
Ялгавартай хий, шар, бадган 3-уул хурж арвидаж, барагдах	5	5	5	5	5	5	30
Шүтээний таван хийн арвидаж, барагдах нийт хувилбар	86	86	86	86	86	86	516
Шүтээний таван шарын арвидаж, барагдахын нийт хувилбар	86	86	86	86	86	86	516
Шитээний таван бадганы арвидаж барагдахын нийт хувилбар	86	86	86	86	86	86	516
Гурван гэмийн арвидаж, барагдахын нийт ангилал	2580	2580	2580	2580	2580	2580	7740

Хүснэгтээс үзвэл “Алтан хадмал” тайлбарт шүтээний ангилалын амь баригч хий нь дангаар болон өөр хоорондоо хавсарч, хурах болон шар, бадгантай тус тусдаа арвидаж, барагдах, машид, дээдэд арвидах, барагдсаны 516 хувилбар болж байгаа бөгөөд энэ хувилбар шүтээний ангиллын бусад 4 хийд мөн адил тус бүрдээ 516 хувилбар болж нийт шүтээний ангиллын 5 хий дангаараа болон бусадтай хавсарч, хурж, арвидах, барагдах, машид, дээдэд арвидах, барагдах байдлаар нийт 2580 хувилбар ангилал болж байна.

Үүнийг дэлгэрүүлэн мөн шүтээний ангиллын 5 шар, 5 бадганы дангаар, хавсарч, хурж арвидах, барагдах, машид, дээдэд арвидах, барагдах байдлаар тус бүр 2580 болж энэ нь биеийн хорлогдохуун 15-д үржигдэж нийтдээ 7740 хувилбар ангилал болгож “Алтан хадмал”-д ангилсан нь өвөрмөц байна.

Мөн тус тайлбарт дээрх 7740 хувилбар ангилал дээр нэмж биеийн үндсэн долоон тамир, 3 хирийн арвидах, барагдах болон дээд, машид арвидах, барагдахын 60 хувилбар гарч байгааг нэмж 7800 хувилбар ангилал болгожээ.

Хүснэгт 2. Долоон тамир, 3 хирийн арвидаж, барагдах өвчний ангилал

1.Тунгалаг 2. Цус 3. Мах 4. Өөх 5. Яс 6. Чөмөг 7. Дусал	Арвидах, дээдэд арвидах, машид арвидах Барагдах, дээдэд баргадах, машид барагдах
Хир 1. Өтгөн 2.Шингэн 3. Хөлс	Арвидах, дээдэд арвидах, машид арвидах Барагдах, дээдэд баргадах, машид барагдах

Түүнчлэн хүснэгт 1,2-т үзүүлсэн өвчний ангиллууд нь шүтээний хий, шар бадганы 15, 7 тамир, 3 хирийн хорлогдохуун 25-т дэлгэрч 7800 өвчний хувилбар ангилал болдог. Энэ ангиллыг өөрийн үндэсний хий, шар бадган арвидаж, барагдах, хямрах, 9 аймагт /машид, дээдэд арвидаж, барагдах/ үржиж дэлгэрснээр 70200 хувилбар ангилал болгожээ.

Мөн энэ нь бусдын үндэсний хий, шар, бадган хавсарсаны арвидах, барагдахын 18 аймагт үржиж дэлгэрснээр 12.636.00 болж байна. Энэ ангилал нь хий, шар, бадганы дангаар арвидах, барагдах, хямрах болон хавсарч арвидаж, барагдахын 27, мөн хурж арвидах, барагдахын 27 нийт 54 хувилбар нь хорлогдохуун 25-д дэлгэрч үржигдснээр 682.344.00 хувилбар өвчний ангилал болж байна. Энэ ангилал дээр хавсарсан 325 өвчин нь арвидах, барагдах, хямрахын 9 аймагт үржигдэн дэлгэрч 2925 хувилбар болж энэ нь мөн 18 аймагт үржиж дэлгэрснээр 52650 хувилбар ангилал болж уламжлалт анагаах ухаанд нийтдээ 682.870.50/ зургаан живаа найман сая хоёр бум найман түм долоон мянга тавь /өвчин байгаа хэмээн үзсэнийг тоон хэмжээлэшгүй хэмээсэн утгаар илэрхийлжээ.

Хэлцэмж: Монголын уламжлалт анагаах ухаанд хүний бие махбодыг дүр эс урвасан эрүүл, дүр урвасан эрүүл бус хэмээн үздэг. Уламжлалт анагаах ухаанд эрүүл биеийг “Хий, шар, бадган гурван махбод, долоон тамир, гурван хир харьцангуй тэнцвэртэй орших” хэмээн тодорхойлоод өвчин бүрд байх адил бус ялгаатай шинжийг үндэслэн өвчний төрөл зүйлд хуваан авч үзсэнийг өвчний ангилал хэмээн тодорхойлжээ. [6]

Уламжлалт анагаах ухаанд өвчнийг ангилахдаа гурван гэмийн хүрээнд шүтээний ангиллын хий, шар, бадган, биеийн 7 тамир, гурван хиртэй холбон тэдгээрийн дан дангаараа болон хавсарч, хурсан хэмжээг тооцон тэдгээрийн арвидах, хорогдох, хямралдах олон хувилбаруудаар нь үржин дэлгэрүүлж өвчний тоо хэмжээлэшгүй олон гэж тодорхойлсон байдгийг нотолж харуулсан байна.[3] Өвчний уламжлалт энэ ангилал эмийн амтын чадлаар найруулж анагаахтай шууд хамааралтай байгаа нь уламжлалт анагаах ухааны онолын ерөнхий хийгээд ялгавартай шүтэн барилдлагыг тодорхойлж байгаагийн зэрэцээ цогц нэгдмэл чанарыг илэрхийлж байна.

Өвчний ангилалын талаар Дарма маарамба Лувсанчойдог “Алтан хадмал” тайлбар бүтээлдээ өвчний 1.Гэмийн арвидах, барагдах, хямралдах өөрчлөлтүүдийг 2. Хорлогдохуун 25-тай холбон машид нарийн үржиж дэлгэрүүлэн тооцож тоогоор илэрхийлж тогтоосон нь бусад тайлбаруудаас өвөрмөц онцлог бүхий байна.

Монголын мэргэдээс анх удаа Ламын гэгээн Лувсанданзанжанцан “Өвчний ялгалыг сайтар үзүүлсэн тодорхойлол оршвой” судартаа “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Номлолын үндэс”-ийн 12-р бүлгийг үндэс болгож өвчнийг ялган үзэх үндсэн зарчим аргыг бичсэн [4] нь онош тавихад дөхөм болжээ гэж үзэхээр байна.

Уламжлалт өвчний ангилал нь өвчний үндсэн болон хавсарсан, ялгах оноош тавих үндсэн баримтлал болохын зэрэгцээ өвчний гэм, орон, эрхэм, язгуурын ангиллыг өөр хооронд нь уялдуулан орчин үеийн анагаах ухааны эмнэлзүйн оноштой дүйцүүлэх боломжтой байна.

Дүгнэлт:

1. “Анагаах ухааны дөрвөн үндэс” сурвалжийн“Номлолын үндэс”-т өвчнийг гэм, эрхэм, орон, язгуурыг баримтлан ангилаад шүтээний ангиллыг эрхэм болгож хорлогдохуун 25-тай холбон дан, хавсарсан, хурсан олон хувилбараар хэмжээлэшгүй олон гэж тодорхойлохдоо хий, шар, бадган гурван гэмийн хүрээнд хязгаарлаж авч үзээд мөн чанарыг баримтлан ерөнхийд нь халуун, хүйтэн 2-т хураажээ.
2. Уламжлалт анагаах ухааны өвчний ангилал нь хий, шар, бадган гурван гэмийн 1. Дангаар 2. Хавсарч 3. Хурж арвидах, барагдах нийт 101 хувилбарыг эх үндэс болгож цаашид хий, шар, бадганы ялгавартай ангилалтай холбон тэдгээрийн тус бүрийн дангаар арвидах, барагдах, хямралдах болон хавсарч машид, дээдэд арвидаж, барагдахын үржвэрүүдээр дэлгэрүүлэн нийтдээ 682.870.50 өвчинд ангилжээ.
3. “Алтан хадмал” тайлбарт өвчний“Шүтээн”-ий ангилал дахь “Эрхэм”-ийн ангиллыг гурван гэмийн дангаараа, хавсарч, хурж арвидаж, барагдахыг хий, шар, бадганы ялгавартай болон 7 тамир, гурван хиртэй болон үржиж дэлгэрүүлэн хэмжээлэшгүй олон ангиллын тоог тодорхой гаргасан нь өвөрмөц онцлогтой байна.

Ном зүй:

1. བདུད་རྩི་ཕྱིང་པོ་ཨ་ཡག་བརྒྱད་པ་གསང་བ་མན་ངག་ཏིལ་ཆུང་ཨེས་བ་བ་བཞུགས་སོ།། *Дүдзинимбо янлаг жадба санва манаггын жүд жэйва шүгсо(Рашааны Шимт Найман Гишүү Нууц Үвдисын Үндэс) 2013 он. Х-5, 9, 41-46, 103, 556*
2. གསོ་བ་རིག་པའི་བསན་བཅོས་སྨན་སྦྱའི་དགོངས་ཆུང་བཞིའ་གསལ་ཁེད་ཀེ་ཆུར་སོན་ཡོའ་མཁ་ཀ་ཞེས་བ་བ་བཞུགས་སོ།། *Сова ригвий санжой манла гонжан жүдши салжэд биндэряа сонбо малга шэва шүгсо. (Хөх Биндэръяа) 2019 он. Х-180, 194, 420,1140*
3. གསེར་མཚན་རྩལ་བག་ནག་མཛོད།། *Сэрчан намда нагзод (Алтан хадмал 35-р*

боть) 2002 он. Х-363, 391,

4. ཨཀཛ་ཆོན་རྩོལ་ཀྱུ་རུ་གསུང་འབུམ་ལས་ནད་ཀྱི་དབྱེ་བའི་ནན་བཤད་གསལ་བྱེད་ཅེས་བྱ་བ་བཞུགས་སོ།། *Ханчэн чойжы жалбо сунвумлай наджи ева намшад салжэд жэйжава шүгсо. (Ламын гэгээн Лувсанданзанжанцан) Х-91, 99*
5. གསོ་རིག་སྒྲུབ་བཞི་འགྲེལ་ཆེན་སྙོང་ཐལ་ཁུངས། *Сориг жүдши дэлчэнданснран шаллүн. (Анагаах язгуур дөрвөн үндсийн дэлгэрэнгүй тайлбар арш гэгээний эш) Х- 271*
6. *С.Сээсрэгдорж, Ч.Чимэдрагчаа, С.Хишигжаргал, Д.Цэрэндагва, Д.Чулуунчимэг, П.Молор-Эрдэнэ "Монголын Уламжлалт Анагаах Ухааны Өвчнийг Анагаах Увдис" 2021 он. Х. 28, 40*
7. *Д.Нацагдорж, Г.Одонцэцэг "УАУ-ны өвчний ангилал зүй" 2001 он УБ Х-37, 45, 57, 140*
8. *Д.Нацагдорж, Г.Одонцэцэг "Өвчний ангилал" 2001 он УБ Х-68*
9. *Д.Нарантуяа. "Чанарын аргын судалгаа" 2012 он. УБ Х-24*
10. *Т.Нарантуяа"Шинжлэх ухааны судалгааны арга зүй" 2013 он УБ Х-12*

Analysis of the classification of the disorders by comparison with the commentaries based on "SQIEBAET" and "Explanatory Tantra"

Byambadolgor D[1], Munkhtuya TS[2], Seesregdorj S[3]

[1,3]MNUMS
[2]Wellness Med
E-mail: byambaadorio@gmail.com, Tel: 88125776

Background: A detailed study of the classification of traditional diseases is considered to be important to determine the nature of the diagnosis of traditional diseases and to equate them with the diagnosis of modern medicine.
Materials and Methods: Hermeneutic methods for translating, interpreting, summarizing and comparing scoure commentariea from Tibetan to Mongolian the concept expressed by the auther is a way that incorporates a wide range of textual analysis.
Results: Theanalysis made using the "Secret Quintessential Instructions on the Eight Branches of the Ambrosia Essence Tantra" and "Explanatory Tantra" is mainly focused on the classification of disorder based on gender; male and female and additional information was found in the commentary books "AltanKhadmal" and "Commentaries of the Four Tantras".
"Explanatory Tantra" from the "Four Tantras" reveals that general disorders are classified on the basis of principle energies, principal dominance, location, and type. Classification based on gender is connected to the principal dormancy type, therefore, making it relevant to the 25 affecting factors to define singular, and combined disorders by considering wind, bile, and phlegm elements and eventually classify them into hot and cold disorders.
Traditional Mongolian Medicine classifies disorders as singular, 2 elements combined, and 3 elements combined due to the accumulated, increased, and decreased states of the 3 elements, totaling 101 versions of the disorder. In addition, increased, decreased, and disturbed states of 3 principle energies make up a total of 682.870.50 disorders.
"AltanKhadmal" commentary book shows that classification on the basis of principal dominance is related to the states of 3 principle elements, 7 bodily constituents, and 3 waste products and their statuses, andthe number of categories that are multiplied and quantified is different from other explanatory books.
Conclusion: Traditional Mongolian Medicine classifies disorders on the basis of 3 principle energies, principal dominance, the location, and the type and focuses more on the principal dominance category and states of the 3 principal elements and multiplied by 25 affecting factors and calculated very precisely.

Key words: TMM, resources, disorder, classification, number